



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын Гурав дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2023/58/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Эрдэнэт хот

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70359826 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах

Утас: 70357955 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn

Аудитор: Г.Даваасүрэн

Утас: 70350757 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2023.02.24 № 44

танай _____-ны № _____-т

**ОРХОН АЙМГИЙН
БАЯН-ӨНДӨР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН
ГУРАВ ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
С.НЯМЦОГТ ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын Гурав дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын Гурав дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын Гурав дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлангийн хугацаанд улсын төсвөөс 1,776,739.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 195,366.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас, 1,908,857.6 мянган төгрөгийн зардлыг зүйл ангиар зарцуулсан байна. Дээрх онцгойлсон асуудалтай холбоотой аудиторын дүгнэлт өөрчлөгдөөгүй болно.

Аудитын гол асуудал

Засгийн газрын 2022 оны 91 дүгээр “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” тогтоолын дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчит ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг хувьсах зардлын дундаж нормативаар буюу гүйцэтгэлд суурилан төсвийг олгож эхэлсэн байна. Гүйцэтгэлд суурилсан төсөвтэй холбоотой жилийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 2023 онд дахин хуваарилан хэрэгжүүлэхээр үлдээсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын Гурав дугаар сургуулийн хичээлийн 1 дүгээр байр 1980 онд ашиглалтад орсноос хойш 42 жил үйл ажиллагаа явуулан насжилт дууссан учир тайланд онд нураасан байна. Үүнээс үүдэн худалдааны төвийн зориулалттай байрыг түрээслэн авч 8 дугаар сард анги танхимын зориулалтаар засаж 9 дүгээр сарын 1-ээс сургалтын үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>146,395,131.21</u>	<u>249,700,842.39</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	8,394.00	43,394,888.24
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	8,394.00	43,394,888.24
3121	Төгрөг	8,394.00	43,394,888.24
31211	Төрийн сангийн харилцах	0.00	43,386,494.24
31213	Арилжааны банк дахь харилцах	8,394.00	8,394.00
33	АВЛАГА	2,220,399.26	2,231,529.26
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,220,399.26	2,231,529.26
35	БАРАА МАТЕРИАЛ	144,166,337.95	204,074,424.89
351	Түүхий эд материал	95,246,081.47	146,058,668.31
35110	Тусгай зориулалттай материал	95,246,081.47	146,058,668.31
354	Хангамжийн материал	48,920,256.48	58,015,756.58
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	2,101,000.00
35470	Бусад хангамжийн материал	48,920,256.48	55,914,756.58
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,605,888,698.20</u>	<u>3,663,888,506.27</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,605,888,698.20	3,663,888,506.27
392	Биет хөрөнгө	2,838,352,558.20	2,890,475,306.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,772,049,230.76	2,772,049,230.76
39202	Хуримтлагдсан элэгдэл	-163,958,024.05	-193,699,286.17
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	328,914,900.13	409,587,215.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	-272,022,816.99	-263,426,340.15
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	137,705,201.18	138,468,176.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	-80,457,129.42	-87,325,306.34
39209	Зам, гүүрийн байгууламж	121,319,517.75	121,319,517.75
39210	Хуримтлагдсан элэгдэл	-5,198,321.16	-6,497,901.45
393	Биет бус хөрөнгө	767,536,140.00	773,413,200.00
39301	Програм хангамж	4,015,550.00	10,015,550.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,679,410.00	-3,802,350.00
39303	Бусад биет бус хөрөнгө	767,200,000.00	767,200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,752,283,829.41</u>	<u>3,913,589,348.66</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,751,394,829.41</u>	<u>3,913,589,348.66</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,751,394,829.41	3,913,589,348.66
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,825,029,836.06	1,825,029,836.06
512	Хуримтлагдсан үр дүн	-121,556,410.45	40,638,108.80
51210	Өмнөх үеийн үр дүн	-121,556,410.45	-3,871,611,446.60
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	3,912,249,555.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,047,921,403.80	2,047,921,403.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,752,283,829.41</u>	<u>3,913,589,348.66</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,556,226,944.80	5,843,630,462.07
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,146,808.98	3,891,378,262.07
120	Нийтлэг татварын бус орлого	11,146,808.98	3,891,378,262.07
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,146,808.98	3,891,378,262.07
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	3,433,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	131,420.00	2,550,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого- Үндсэн хөрөнгө	2,865,500.00	3,684,432,474.02
120018	Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого- Бараа материал	7,124,796.03	200,962,688.05
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,545,080,135.82	1,952,252,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,439,655,000.00	1,770,756,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	1,770,756,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	80,676,700.00	181,495,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	80,676,700.00	181,495,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,608,385,163.67	1,931,380,906.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,608,385,163.67	1,931,380,906.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,584,452,373.88	1,800,673,692.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,199,007,010.04	1,412,759,699.13
210101	Үндсэн цалин	578,659,974.06	907,713,768.13
210102	Нэмэгдэл	520,338,261.80	457,226,762.00
210104	Урамшуулал	97,256,374.18	47,819,169.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	157,784,189.84	177,691,629.63
210201	Тэтгэврийн даатгал	111,150,786.05	123,402,850.18
210202	Тэтгэмжийн даатгал	12,249,213.45	14,063,844.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,641,452.64	11,089,616.04
210204	Ажилгүйдлийн даатгал	2,249,339.48	2,648,635.57
210205	Эрүүл мэндийн даатгал	22,493,398.22	26,486,683.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,566,404.33	68,971,114.27
210301	Гэрэл, цахилгаан	7,546,567.32	11,507,979.10
210302	Түлш, халаалт	29,012,410.02	26,879,009.58
210303	Цэвэр, бохир ус	15,007,426.99	30,584,125.59
2104	Хангамж, бараа материалын зардал	11,156,860.00	20,947,419.20
210401	Бичиг хэрэг	3,685,450.00	4,464,550.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,611,900.00	16,482,869.20
2105	Нормативт зардал	55,992,500.00	330,590.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	889,300.00	330,590.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,762,700.00	5,999,800.00
210604	Урсгал засвар	14,562,700.00	5,999,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,447,900.00	14,678,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,447,900.00	3,433,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	11,245,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,857,809.67	99,295,340.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,128,940.00	25,942,029.96
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,731,940.00	18,647,343.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	68,996,929.67	54,705,967.75
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,932,789.79	130,707,213.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,532,234.00	124,716,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	124,716,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,899,595.67	5,991,213.73
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,899,595.67	5,991,213.73
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-52,158,218.87	3,912,249,555.40
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-53,777,592.87	3,912,249,555.40

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,551,933,957.82	1,959,209,509.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	131,420.00	5,983,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	131,420.00	5,983,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	131,420.00	5,983,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	3,433,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	131,420.00	2,550,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,551,802,537.82	1,953,226,409.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,439,655,000.00	1,770,756,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	1,770,756,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	80,676,700.00	181,495,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	80,676,700.00	181,495,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	11,594,576.00	974,209.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	11,594,576.00	974,209.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,542,058,196.00	1,881,661,014.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,542,058,196.00	1,881,661,014.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,458,960,104.21	1,749,979,592.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,198,231,010.04	1,413,911,829.13
210101	Үндсэн цалин	578,323,536.06	940,437,185.13
210102	Нэмэгдэл	520,819,699.80	425,681,007.00
210104	Урамшуулал	52,251,952.18	47,793,637.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	157,784,189.84	177,691,629.63
210201	Тэтгэврийн даатгал	111,150,786.05	123,402,850.18
210202	Тэтгэмжийн даатгал	12,249,213.45	14,063,844.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,641,452.64	11,089,616.04
210204	Ажилгүйдлийн даатгал	2,249,339.48	2,648,635.57
210205	Эрүүл мэндийн даатгал	22,493,398.22	26,486,683.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,566,404.33	68,971,114.27
210301	Гэрэл, цахилгаан	7,546,567.32	11,507,979.10
210302	Түлш, халаалт	29,012,410.02	26,879,009.58
210303	Цэвэр, бохир ус	15,007,426.99	30,584,125.59

2104	Хангамж, бараа материалын зардал	10,222,410.00	18,134,650.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,979,400.00	18,134,650.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,503,700.00	5,999,800.00
210604	Урсгал засвар	14,103,700.00	5,999,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,447,900.00	14,678,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,447,900.00	3,433,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	11,245,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,897,690.00	50,592,469.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	963,540.00	31,803,475.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,934,150.00	18,788,994.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	83,098,091.79	131,681,422.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	66,697,536.00	125,690,209.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	11,594,576.00	974,209.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	52,551,900.00	124,716,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,899,595.67	5,991,213.73
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,899,595.67	5,991,213.73
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	9,875,761.82	77,548,494.24
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,399,830.00	34,162,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,399,830.00	34,162,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,399,830.00	34,162,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,399,830.00	34,162,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-9,399,830.00	-34,162,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	475,931.82	43,386,494.24
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		8,394.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,394.00	43,394,888.24

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,825,029,836.06	2,047,921,403.80	(121,556,410.45)	3,751,394,829.41
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(3,750,055,036.15)	(3,750,055,036.15)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	(3,750,055,036.15)	(3,750,055,036.15)
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	3,912,249,555.40	3,912,249,555.40
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,825,029,836.06	2,047,921,403.80	40,638,108.80	3,913,589,348.66

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /улсын төсөв/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,776,739,900.00	1,733,353,405.76	43,386,494.24	97.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,776,739,900.00	1,733,353,405.76	43,386,494.24	97.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,650,498,800.00	1,608,637,405.76	41,861,394.24	97.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,361,164,800.00	1,340,870,101.13	20,294,698.87	98.51
210101	Үндсэн цалин	965,930,200.00	907,256,798.13	58,673,401.87	93.93
210102	Нэмэгдэл	359,659,800.00	385,819,666.00	-26,159,866.00	107.27
210104	Урамшуулал	35,574,800.00	47,793,637.00	-12,218,837.00	134.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	170,145,600.00	168,334,735.63	1,810,864.37	98.94
210201	Тэтгэврийн даатгал	115,699,000.00	116,966,356.18	-1,267,356.18	101.10
210202	Тэтгэмжийн даатгал	13,611,700.00	13,333,844.04	277,855.96	97.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,889,300.00	10,505,616.04	383,683.96	96.48
210204	Ажилгүйдлийн даатгал	2,722,300.00	2,502,635.57	219,664.43	91.93
210205	Эрүүл мэндийн даатгал	27,223,300.00	25,026,283.80	2,197,016.20	91.93
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,984,600.00	14,678,100.00	1,306,500.00	91.83
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,551,500.00	11,245,000.00	1,306,500.00	89.59
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	103,203,800.00	84,754,469.00	18,449,331.00	82.12
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	84,376,600.00	65,965,475.00	18,411,125.00	78.18
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,827,200.00	18,788,994.00	38,206.00	99.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	126,241,100.00	124,716,000.00	1,525,100.00	98.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	126,241,100.00	124,716,000.00	1,525,100.00	98.79
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	126,241,100.00	124,716,000.00	1,525,100.00	98.79
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	43,394,888.24		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	0	0	0	0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	72	72	0	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	73	72	1	98.63
620003	Үйлчлэх ажилтан	26	26	0	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	916	990	-74	108.08
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	916	990	-74	108.08
630001	Төрийн өмчит ЕБС	916	990	-74	108.08
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	100	99	1	99.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	64	64	0	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	32	31	1	96.88
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	2	2	0	100.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	2	2	0	100.00

Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /орон нутаг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	195,366,700.00	175,504,186.27	19,862,513.73	89.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	195,366,700.00	175,504,186.27	19,862,513.73	89.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	195,366,700.00	175,504,186.27	19,862,513.73	89.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	84,637,600.00	73,041,728.00	11,595,872.00	86.30
210101	Үндсэн цалин	60,557,400.00	33,180,387.00	27,377,013.00	54.79
210102	Нэмэгдэл	11,189,500.00	39,861,341.00	-28,671,841.00	356.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,632,400.00	9,356,894.00	2,275,506.00	80.44
210201	Тэтгэврийн даатгал	7,910,100.00	6,436,494.00	1,473,606.00	81.37
210202	Тэтгэмжийн даатгал	930,400.00	730,000.00	200,400.00	78.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	744,400.00	584,000.00	160,400.00	78.45
210204	Ажилгүйдлийн даатгал	186,100.00	146,000.00	40,100.00	78.45
210205	Эрүүл мэндийн даатгал	1,861,400.00	1,460,400.00	401,000.00	78.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,889,700.00	68,971,114.27	5,918,585.73	92.10
210301	Гэрэл, цахилгаан	16,478,400.00	11,507,979.10	4,970,420.90	69.84
210302	Түлш, халаалт	34,720,300.00	26,879,009.58	7,841,290.42	77.42
210303	Цэвэр, бохир ус	23,691,000.00	30,584,125.59	-6,893,125.59	129.10
2104	Хангамж, бараа материалын зардал	18,207,000.00	18,134,650.00	72,350.00	99.60
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,207,000.00	18,134,650.00	72,350.00	99.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,000,000.00	5,999,800.00	200.00	100.00
210604	Урсгал засвар	6,000,000.00	5,999,800.00	200.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	195,366,700.00	175,504,186.27	19,862,513.73	89.83
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	195,366,700.00	175,504,186.27	19,862,513.73	89.83
320001	Орон нутгийн төсвөөс	195,366,700.00	175,504,186.27	19,862,513.73	89.83
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	8,394.00		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,983,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,983,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,683,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,433,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,433,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,550,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,550,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,983,100.00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,983,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,433,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,550,000.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 6,970.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 1,530.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 3,000.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2,440.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Багшийн сургалтын "Цахим хэрэглээний зардал"-д зориулсан Юнител ХХК-ны дата багцыг 29 үндсэн багшаас гадна захирал, менежер, нягтлан бодогч, нийгмийн ажилтан, нярав, архив бичиг хэрэг, зэрэг 12 албан хаагчид 720,0 мянган төгрөгийг илүү зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно:", 12.1.1-т "гар утасны зардал", Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цахим хэрэглээний зардлыг төлөвлөх хуваарилах заавар"-ын 2.4-д "дата багцыг сонгосон нөхцөлд цахим хэрэглээний нийт зардлыг нийт үндсэн багш (бүлгийн болон хөгжим, биеийн тамирын багшийн нийт тоо) тоонд хувааж тухайн хугацаанд ашиглах цахим хэрэглээний зардлын нэгжийг тооцно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2. Тус сургууль нь цайны газрын түрээсийн орлого 810,0 мянган төгрөгийг бэлнээр авч зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 3.12-д "Эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд ажлын 1 хоногт багтаан тушааж сар бүрийн эцэст зарагдсан тасалбарын бүртгэл болон орлого цуглуулсан баримтын (зарагдсан тасалбараас өөрт үлдэх хувь) тооцоог гаргаж, тайланг тушаана.", 2.2-д "Төсвийн байгууллага нь арилжааны банкны төлбөрийн картын дансанд байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай бэлэн мөнгийг төрийн сангаас баталсан хязгаар/ЖМС/-ын дотор шилжүүлэн авч болох бөгөөд гадаад, дотоод албан томилолт, гадаад зочны зардал, тэтгэмж, урамшуулал, шагналыг батлагдсан төсвийн хүрээнд шилжүүлэн авч болно.", 2.3-д "Журмын 2.2-д зааснаас бусад зардлаас зайлшгүй бэлнээр гүйлгээ хийлгэх шаардлагатай тохиолдолд албан хүсэлт, шаардлагатай хөрөнгийн баталсан төсөв, бэлнээр авах үндэслэлийг тодорхой тусгаж ирүүлнэ. Төрийн сан албан хүсэлтийг хянаж үзэн, шаардлагатай гэж үзвэл бэлнээр олгож болно." гэж заасныг зөрчсөн байна.

5.2 Албан шаардлага

Тус сургууль нь бичиг хэрэг, бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас 3,000,0 мянган төгрөгийн бараа материалыг төлбөрийн баримтгүй худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

болно.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

5.3 Зөвлөмж

1. Зардлын эдийн засгийн ангилалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цалингийн зардлаас албан хаагчдын шагналд 2,440,0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал зардлын "ажилчдын цалин хөлс болон хуулиар нийгмийн даатгалын шимтгэл бодогдох нэмэгдэл урамшууллын зардлууд энэ ангилалд хамаарна" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, эдийн засгийн ангиллаар зарцуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	/мянган төгрөгөөр/ Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын Гурав дугаар сургууль	4	6,970.0	2	1.530,0	1	3,000.0	1	2,440.0	4			
Дүн	4	6,970.0	2	1.530,0	1	3,000.0	1	2,440.0				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		Аудит хийгээгүй	7	8				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	+			+			
2									
3									
	НИЙТ	1	+			+			